



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/695.

Ховд

Үйлчилгээний байгууллагуудын үйл
ажиллагааг түр хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, “ж”, “л” заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 27 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотод Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, үйлчилгээний төв, дэлгүүр, баар, караоке, ресторан, кафе, зоогийн газруудыг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06.00 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06.00 цаг хүртэл хугацаанд худалдах, түүгээр үйлчлэхийг хязгаарласугай.

2. Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нар, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/695-Bo